



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 0104

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны А/28 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нэгдүгээр хорооны 2, 3, 4, 5, 6 дугаар байр, хоёрдугаар хорооны 5, 6, 7, 9, 12, 13, 16 дугаар байрны орон сууцнуудын фасадны өнгө сэргээх засварын ажлын зураг төсөв боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч О.Содовжамц

Худалдан авах ажиллагааны албаны дарга

Гишүүд Ё.Гэрэлцэцэг

Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн Худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл хариуцсан Ахлах мэргэжилтэн Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын инженер

Б.Хишиг-Ундрал

1 дүгээр хорооны иргэн

Х.Батсайхан

Нарийн бичиг

Э.Урансайхан

Худалдан авах ажиллагааны албаны Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Хууль тогтоомжийн дагуу зураг төсөв боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Ажлын хэсэг (О.Содовжамц)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД